



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 1307

Улаанбаатар хот

“Ус сувгийн удирдах газар” орон нутгийн  
өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн  
газрын эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 128 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/892 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтүүдээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хавсралтад заасан нийт 441,332,221.45 /дөрвөн зуун дөчин нэгэн сая гурван зуун гучин хоёр мянга хоёр зуун хорин нэгэн төгрөг дөчин таван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 16 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /Ц.Төрхүү/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 3,720,760 /гурван сая долоон зуун хорин мянга долоон зуун жаран/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийслэлийн Төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэх, акт болон бусад баримт бичгийн бүрдэлтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийхийг “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /Ц.Төрхүү/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ




D:\Tushaal\2019\Tushaal-1\8 cap.docx

1119232495 2576589

115050000957

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 09 дугаар сарын 02 өдрийн 0.00 дугаар тушаалын хавсралт



АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Нэгжийн үнэ /төгрөг/	Байгуулсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл үнэ /төгрөг/	Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт	Түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах үнэ
1	Складын барилга	БЗД. 3-р хороо	61	1,237,970.92	-	1,237,970.92	2019 оны 02-07-395/110 дугаар дүгнэлт	500,760.00
2	Гаражийн барилга	БЗД. 3-р хороо	21	1,694,853.64	-	1,694,853.64	2019 оны 02-07-395/110 дугаар дүгнэлт	1,320,000.00
3	Барилга ТЦБ уурын зуух	СХД. 20-р хороо	60	398,346,162.70	348,369,415.42	49,976,747.28	2018 оны 07/100/271 дүгээр дүгнэлт	1,200,000.00
4	Ус түгээх байр-122	ЧД. 15-р хороо, Жаргалантын 6-р гудамж	40	689,102.82	-	689,102.82	2013 оны 02-07-95/834 дугаар дүгнэлт	50,000.00
5	Ус түгээх байр-26	БЗД. 8-р хороо, Холбоо толгойн 1-р гудамж	13	717,938.42	-	717,938.42	2018 оны 02-07-136/1041 дүгээр дүгнэлт	50,000.00
6	Ус түгээх байр-07	БЗД. 17-р хороо, Шархадны 3-р гудамж	9	153,487.15	-	153,487.15	2018 оны 02-07-136/1041 дүгээр дүгнэлт	-
7	Ус түгээх байр-69	БЗД. 27-р хороо, Сэлбийн гудамж	7	270,191.88	-	270,191.88	2018 оны 02-07-136/1041 дүгээр дүгнэлт	50,000.00

8	Ус түгээх байр-249	СХД. 8-р хороо, Баянцагааны 9-р гудамж	41	890,043.84	-	890,043.84	2018 оны 02-07- 094/858 дугаар дүгнэлт	40,000.00
9	Ус түгээх байр-260	СХД. 25-р хороо, Одонтын 8-р гудамж	24	643,011.26	-	643,011.26	2018 оны 02-07- 094/858 дугаар дүгнэлт	40,000.00
10	Ус түгээх байр-86	СБД. 17-р хороо, Дамбадаржаагий н 69-р гудамж	7	153,487.15	-	153,487.15	2018 оны 02-07- 136/1041 дүгээр дүгнэлт	50,000.00
11	Ус түгээх байр-513	СБД. 18-р хороо, Бэлхийн 53-р гудамж	13	343,341.18	-	343,341.18	2018 оны 02-07- 095/1269 дүгээр дүгнэлт	60,000.00
12	Ус түгээх байр-528	ЧД. 19-р хороо, Доод салхитын 9- р гудамж	9	308,448.00	-	308,448.00	2018 оны 02-07- 095/1269 дүгээр дүгнэлт	100,000.00
13	Ус түгээх байр-582	ЧД. 16-р хороо, Согоотын 32-р гудамж	36	7,437,699.07	7,437,699.07	-	2018 оны 02-07- 095/1269 дүгээр дүгнэлт	50,000.00
14	Ус түгээх байр-653	СХД. 11-р хороо, Хөтөлийн 5-р гудамж	29	12,973,003.42	12,973,003.42	-	2018 оны 02-07- 095/1269 дүгээр дүгнэлт	100,000.00
15	Ус түгээх байр-723	СХД. 6-р хороо, Тоосгоны 33-р гудамж	39	7,124,480.00	7,124,480.00	-	2018 оны 02-07- 095/1269 дүгээр дүгнэлт	50,000.00
16	Ус түгээх байр-777	ХУД. 12-р хороо, Био 8-р гудамж	44	8,349,000.00	8,349,000.00	-	2018 оны 02-07- 095/1269 дүгээр дүгнэлт	60,000.00
	Актлах барилга, байгууламжийн дүн			441,332,221.45	384,253,597.9 1	57,078,623.54		3,720,760.00